



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3 - 4

1. *“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол* 3 - 4

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 05 дугаар сарын 03-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 40 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Мөнх-Оргил;

Чөлөөтэй: Б.Энхбаяр, Н.Алтанхуяг, Д.Ганбат, Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд, Ж.Сүхбаатар, Ц.Сэргэлэн.

Нэг. “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бат.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Энх-Амгалан: “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 14 цаг 44 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордны “Үндсэн хууль” танхим
14 цаг 40 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Энх-Амгалан: Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хууль зүйн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдаанд ирсэн ирцийг танилцуулъя.

Б.Энхбаяр гишүүн чөлөөтэй, Ш.Адъяаа гишүүн ирсэн, Н.Алтанхуяг гишүүн чөлөөтэй, Э.Бат-Амгалан гишүүн ирсэн, С.Бямбацогт гишүүн ирсэн, Д.Ганбат гишүүн чөлөөтэй, Б.Дэлгэрсайхан гишүүн ирсэн, Л.Мөнхбаатар гишүүн ирсэн, Ц.Мөнх-Оргил гишүүн гадаад томилолттой, Ц.Мөнхцэцэг гишүүн ирсэн Х.Нямбаатар гишүүн чөлөөтэй, Б.Пүрэвдорж гишүүн чөлөөтэй, Ш.Раднаасэд гишүүн чөлөөтэй, Ц.Сандаг-Очир гишүүн ирсэн, Ж.Сүхбаатар гишүүн чөлөөтэй, Ц.Сэргэлэн гишүүн өвчтэй, Н.Учрал гишүүн ирсэн, Д.Цогтбаатар гишүүн ирсэн, Б.Энх-Амгалан гишүүн ирсэн.

Ирцийг хяналтууд дууслаа.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Засгийн газар 2023 оны 01 сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан тогтоол байна.

Хэлэлцэх асуудлыг гишүүдэд тараасан.

Тогтоолыг гишүүдэд тараасан байгаа учраас тогтоолын төсөлтэй холбоотойгоор асуулт асуух гишүүн байвал нэрээ өгнө үү. Алга байна. /алх цохив/

Тогтоолын төсөлтэй холбоотойгоор санал хэлэх гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүдэд асуулт асууж дууссан. Санал хэлж дууссан.

“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Хуультай холбоотойгоор “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

11 гишүүн оролцсоноос 7 гишүүнийг дэмжиж, 63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Ш.Адьяаа гишүүн танилцуулья.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье.

Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүдэд баярлалаа.

Ш.Раднаасэд гишүүнийг ирснээр бүртгээрэй.

Хуралдаан 4 минут үргэлжилж, 14 цаг 44 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД